



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/03-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2024 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.	ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	1
2.	АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
5.	АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.1	Зөвлөмж.....	8
6.	АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХАЙРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.ЧОЙЖЖАНЦАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 158

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хайрхан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Хайрхан сумын засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 178 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 90.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	568,680.3	781,617.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	167,192.6	384,872.3
33	АВЛАГА	326,203.6	310,889.8
35	БАРАА МАТЕРИАЛ	75,284.1	85,854.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,245,520.4	2,768,367.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,245,520.4	2,768,367.3
39200	Биет хөрөнгө	2,223,240.4	2,751,146.1
39300	Биет бус хөрөнгө	22,280.0	17,221.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,814,200.8	3,549,984.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,401.7	54,196.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,401.7	54,196.0
41300	Өглөг	8,401.7	54,196.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,805,799.1	3,495,788.3
51	Засгийн газрын хувь оролцоо	2,805,799.1	3,495,788.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	450,071.4	450,071.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,808,395.1	2,498,384.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,332.5	547,332.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,814,200.8	3,549,984.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,999,636.0	2,591,397.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	389,631.0	425,150.0
110	Орлогын албан татвар	243,012.5	279,778.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	242,993.6	279,688.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	18.9	90.0
113	Хөрөнгийн албан татвар	90,170.1	61,425.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,448.5	83,946.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	533,262.9	923,086.2
120	Нийтлэг татварын бус орлого	533,262.9	923,086.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,076,742.0	1,243,161.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,806,881.4	1,538,760.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,448,583.4	1,538,760.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,251,565.5	1,534,918.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,537.1	422,932.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,918.7	53,049.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	475,858.3	94,028.7
2104	Хангамж, бараа материалын зардал	23,647.1	46,475.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,263.2	1,200.0
2107	Томилолт, зочны зардал	3,083.2	5,873.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,867.2	642,132.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	252,390.8	269,226.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,197,017.9	3,842.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	358,298.0	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	192,754.5	1,052,637.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,820,591.0	358,288.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,627,836.4	694,349.2

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,716,585.6	2,058,079.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	389,631.0	425,150.0
110	Орлогын албан татвар	243,342.4	279,778.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	243,323.5	279,688.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	18.9	90.0
113	Хөрөнгийн албан татвар	89,840.2	61,425.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,448.5	83,946.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,406.4	31,153.0
1181	Газрын төлбөр	15,700.0	42,891.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,342.1	9,901.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	250,212.5	389,767.4
120	Нийтлэг татварын бус орлого	250,212.5	389,767.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,076,742.0	1,243,161.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,325,561.4	1,452,977.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,325,561.4	1,452,977.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,104,102.6	1,449,134.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,436.8	504,672.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,740.0	78,731.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	483,232.5	119,021.0
2104	Хангамж, бараа материалын зардал	82,790.6	134,554.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,263.2	2,000.0
2107	Томилолт, зочны зардал	3,083.2	5,873.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,922.1	565,217.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,634.2	39,064.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,221,458.8	3,842.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	391,024.2	605,102.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	377,647.8	387,422.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	377,647.8	387,422.4
2200	Дотоод эх үүсвэрээр	377,647.8	387,422.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-377,647.8	-387,422.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-195,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	195,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-181,623.6	217,679.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	348,816.3	167,192.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	167,192.6	384,872.3

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,514,737.9	7,514,737.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-81,102.4	-81,102.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,433,635.5	7,433,635.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-4,627,836.4	-4,627,836.4
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,805,799.1	2,805,799.1

Архангай аймгийн Хайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,805,799.1	2,805,799.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,360.0	-4,360.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,801,439.1	2,801,439.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	694,349.2	694,349.2
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,495,788.3	3,495,788.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,943,039.9	1,499,902.5	443,137.4	77.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,268,628.1	1,160,859.5	107,768.6	91.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,264,778.1	1,157,017.4	107,760.7	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,760.9	422,932.7	36,828.2	92.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,470.1	53,049.4	4,420.7	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	636,795.1	574,399.4	62,395.7	90.2
2104	Хангамж, бараа материалын зардал	35,111.9	35,015.2	96.7	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,400.0	13,054.3	1,345.7	90.7
2107	Томилот, зочны зардал	6,180.0	5,873.4	306.6	95.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,099.2	32,758.8	2,340.4	93.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,960.9	19,934.2	26.7	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,850.0	3,842.1	7.9	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,850.0	3,842.1	7.9	99.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	531,567.2	339,043.0	192,524.2	63.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	142,844.6	-	142,844.6	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,943,039.8	1,534,497.6	408,542.2	79.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,681,553.8	1,477,425.6	204,128.2	87.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	261,486.0	57,071.9	204,414.1	21.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		114,714.9	(114,714.9)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		149,309.5	(149,309.5)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8		100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28		100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,070.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,070.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,284.9
2104	Хангамж бараа материалын зардал	1,735.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,419.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,130.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	786.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	786.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,070.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,070.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй. Харин залруулагдаагүй нийт 19,973.8 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 2 зөвлөмж хүргүүлээ. Энэхүү илэрсэн зөрчил нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдал 21,859.2 мянган төгрөгөөс доогуур байгаа тул Зөрчилгүй дүгнэлт хүргүүлэв.

3.1 Зөвлөмж

3.1.1 Зээлийн авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд зээл авсан "Өгөөмөр дөрвөн бэрх" хоршооны 2023 онд төлөх үндсэн төлбөр 8,750.0 мянган төгрөг, хүүгийн төлбөр 3,152.9 мянган төгрөг, "Хөгжлийн түүчээ" хоршооны 2023 онд төлөх үндсэн төлбөр 7,083.3 төгрөг, хүүгийн 987.4 мянган төгрөг, нийт 19,973.6 мянган төгрөгийн тайлант хугацаанд хамаарах хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 10 дугаар зүйлийн 10.1-т "Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина.", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэсэн заалтыг зөрчиж байна.

Зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийг зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах

3.1.2 Орон нутгийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг тулган шалгахад 2023 онд орон нутгийн төсвийн орлогод 19 нэр төрлийн 462,962.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 443,489.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт орлогыг 95.8-иар биелүүлсэн байна. Орлого 4.2 хувиар тасрахад гол нөлөө үзүүлсэн орлого нь малын тоо толгойн албан татварын орлого бөгөөд тус орлогын төлөвлөгөөний биелэлт нь 2023 оны хаваржилт болон өвөлжилт хүндэрч мал ихээр хорогдсоноос шалтгаалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмж: Орлогын төлөвлөлтөд анхаарч, нийт дүнгээр орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллах арга хэмжээг авах

Зөвлөмжийн биелэлтийг тооцож, холбогдох нотлох баримтын хамт 2024 оны 12 дугаар сарын 05-ны дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй	1	19973.6					1	19973.6				
Орлогын төлөвлөгөөний биелэлт 95.8 хувьтай	1	0					1	0				
	1	19973.6					2	19973.6				